



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 7/24

Есөнбулаг сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоомж, Засгийн газрын болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах "Тэмээ өсгөж, ашиг шимийг нэмэгдүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд зохион байгуулагдаж буй "ЗАСАГТ ХАН-2026" тэмээчдийн зөвлөгөөн, бага наадмын арга хэмжээнд Уран сайхны нийтлэл, цуврал тэмдэглэл бэлтгэж, сурталчлах ажлыг сэтгүүлч Галсангийн Болормаатай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2. Гэрээний зардалд шаардагдах 5.600.000 (таван сая зургаан зуун мянган) төгрөгийг Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулан ажлыг чанартай гүйцэтгүүлэн тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Хэвлэлийн алба (Д.Баяраа)-д үүрэг болгосугай.

4. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж хамтарч ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

8200010217

